

Аудит хийх үндэслэл, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Төв аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн дагуу хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга, хэмжээний зардлыг бүрдүүлж зарцуулахад тавих дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй байна.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



АГУУЛГА

ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Товчилсон үгийн тайлбар	3
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ 1. А. Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолтой нийцүүлэн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг санхүүжүүлж байна.	5
Аудитор Д.Пүрэвсүрэн	БҮЛЭГ 2. Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөсөн боловч, орлогыг дутуу төлөвлөж, батлуулсан байна.	7
Ахлах аудитор Ц.Саранчимэг	БҮЛЭГ 3. В. Зарим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зураг төсөвгүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, зориулалтыг өөрчлөх, гэрээгээ дүгнээгүй байх зэрэг хууль, журам бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил байна.	10
2016 оны 10 дугаар сарын 09	БҮЛЭГ 4.Г. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж ажилласан байна.	16
Уг тайланг АГ-ын Веб сайтаас үзнэ үү.		
www.audit.mn	Дүгнэлт	18
	Зөвлөмж	19
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 70272287 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу.	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	20
ХАЯГ:	Холбогдох байгууллагын саналын дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ	
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон		

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТББ	Тендерийн бичиг баримт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
ААН	Аж ахуйн нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт:

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогыг хууль журмын дагуу бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалган дүгнэлт, зөвлөмж, боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын хамрах хүрээ:

Аудитыг аймгийн ЗДТГазрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумдын Засаг дарга, байгаль орчныг хариуцсан ажилтнуудын санхүүгийн баримт материал, аймгийн ИТХ-аас батласан төсвийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй:

Аудитыг АОУС 4200, гүйцэтгэлийн аудитын гарын авлагыг ашиглан байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга авах болон бусад баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Усны тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Ойн тухай хууль
- Амьтны тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам.
- Аймгийн ИТХ-ын ус, ургамал, ой, ан амьтан агнах зэрэг байгалийн нөөц ашиглах төлбөр, хураамжийг тогтоосон тогтоол, шийдвэрүүд
- Аймгийн ИТХ-ын холбогдох тогтоолууд

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Ц.Саранчимэг, аудитор Д.Пүрэвсүрэн нар 2016 оны 9 дүгээр сарын 01-ноос 10-р сарын 05-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

Бүлэг1

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолтой нийцүүлэн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зохицуулж байна.

А.1. Сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн үү?

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолтой нийцүүлэн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зохицуулж байна.

Аймгийн Байгаль хамгаалах сан нь 2015.01.01-нийг хүртэл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Аймаг, сумын байгаль орчныг хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн.

Төсвийн тухай /шинэчлэсэн найруулга/ хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т “Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх”, мөн хуулийн 58.2.13-т “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх” гэсэн заалт, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2014.02.14-ний 43 дугаар тушаалаар баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу аймгийн ИТХ-аар Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг баталж, аймгийн БОАЖГазраар дамжуулан санхүүжүүлж, зарцуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 2015 оноос тусгайлан “Байгаль хамгаалах сан” гэсэн дансаар дамжуулан үйл ажиллагаа явуулаагүй байна.

А.2. Хууль дүрэм журмууд нь сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадаж байна уу?

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолтой нийцүүлэн Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Аймаг, сумын байгаль орчныг хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ыг хүчингүй болгосон байна.

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн асуудлыг Төсвийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиудын хүрээнд Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.4 дэх заалтын дагуу зохицуулж байна.

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолтой нийцүүлэн аймгийн ИТХ-ын 2016 оны гурав дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны 5 тоот тогтоолын 8-д Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Аймаг, сумын байгаль орчныг хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хүчингүй болгосон байна.

Аймгийн ИТХ-аар “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу газрын төлбөрийн орлого, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын тодорхой хувийг, сумдын ИТХ-аар ой, ан агнуур, ус рашаан, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын хуулинд заасан тодорхой хувиар төлөвлөж тус орлогоор аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрийг бүрдүүлж байна.

Төв аймгийн хувьд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийг төлөвлөх, хувиарлах, батлах, зарцуулах асуудал холбогдох жууль, журмын дагуу явагдаж буй хэдий ч дээрх арга хэмжээнд зарцуулах санхүүжилт аймгийн БОАЖГ-ын төсвийн дансаар дамжин зарцуулагдаж байна. Орон нутагт байгаль орчныг хамгаалах сангийн данс байхгүй болж хөтөлбөрт суурилсан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалыг зарцуулах байгууллага, дансны асуудал зохицуулалтгүй орхигдсон байна.

А.3. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм журмууд нь бусад хууль, тогтоомжтой нийцэж байна уу?

Аймгийн ИТХурлын шийдвэр нь холбогдох хууль, дүрэм, журманд нийцэж байна.

Аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг бүрдүүлж зарцуулахад Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.13, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал” зэрэг хууль, журамд нийцүүлэн аймгийн ИТХурлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бүлэг 2

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөсөн боловч, орлогыг дутуу төлөвлөж, батлуулсан байна.

Б.1. Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу үндэслэлтэй төлөвлөсөн байна уу?

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөсөн боловч, орлогыг хуульд заасан хувь хэмжээнээс дутуу төлөвлөж, батлуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1, 18.1-д “байгалийн нөөцийн төлбөрийн орлогын тодорхой хувиар санхүүжүүлэхээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал батална” гэж заасныг үндэслэн аймгийн ИТХ-аар төлөвлөгөөг батлуулжээ.

- Аймгийн ИТХ-ын 2015 оны Аравдугаар хуралдааны 08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2015 оны төлөвлөгөөнд 9 төсөл арга хэмжээг 593.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

	Төсөл арга хэмжээний нэр байршил	Ажлын хэмжээ	Мөнгөн дүн /сая төг/
1	Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллыг цэвэр, бохир усны байгууламжтай болгох		200.0
2	Шинэчлэл цэцэрлэгт хүрээлэнд ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлэн дуусгах	2.1	61.4
3	Үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах төсөл хэрэгжүүлэх		161.5
4	Сумын БОХ-ын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум дундын ойн анги, идэвхтэн байгаль хамгаалагчдын сургалт зохион байгуулах		4.8
5	Усны тооллогыг явуулж, сав газруудын зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, ААН байгууллагын оролцоог нэмэгдүүлэн сургалт сурталчилгаа явуулах.	5 сав газар	5.0
6	Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цэвэрлэх байгууламж барих / Сүмбэр сум/		80.0
7	Сумдын усан сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох	сумд	26.0
8	Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх	100 өрх	24.5
9	Манзуширын тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулах, менежментийг сайжруулах		30.2
	Дүн		593.4

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тооцож үзвэл газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 1566.6 сая төгрөгөөр төлөвлөсний 15 хувиар буюу 235.0 сая төгрөг, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар усны нөөц ашигласны төлбөрийг 1557.1 сая төгрөгөөр төлөвлөсний 35 хувь буюу 545.0 сая төгрөг,

нийт 780.0 сая төгрөгөөр төлөвлөхөөр тооцогдож байна. Гэтэл аймгийн ИТХ-ын хуралдаанаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 593.4 сая төгрөгөөр баталсан нь хуульд заасан хувь хэмжээнээс 186.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөгдөж, батлагдсан байна.

- Аймгийн ИТХ-ын 2015 оны Арван нэгдүгээр хуралдааны 09 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2016 оны төлөвлөгөөнд 2 төсөл арга хэмжээг 486.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

№	Төсөл арга хэмжээний нэр байршил	Ажлын хэмжээ	Мөнгөн дүн /сая төг/
1	Зуунмод сумын усан санг автоматжуулж, тоолууржуулах төсөл арга хэмжээг санхүүжүүлэх		300.0
2	Аргалант, Зуунмод сумын голын эхэнд хөв, цөөрөм байгуулах		186.3
	НИЙТ		486.3

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу төлөвлөсөн газрын төлбөрийн орлого 1482.5 сая төгрөгөөр төлөвлөсний 15 хувиар буюу 222.4 сая төгрөг, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 1389.3 сая төгрөгөөр төлөвлөсний 35 хувь буюу 486.3 сая төгрөг, нийт 708.4 сая төгрөгөөр төлөвлөгдөхөөр тооцогдож байна. Гэтэл аймгийн ИТХ-ын хуралдаанаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 486.3 сая төгрөгөөр баталсан нь хуульд заасан хувь хэмжээнээс 222.1 сая төгрөгөөр дутуу төлөвлөгдөж, батлагджээ.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрийг хуульд заасан хувь бүрэн хэмжээгээр төлөвлөөгүй байна.

Б.2. Сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төрөл тус бүрээр бүрдүүлсэн үү?

2015 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөсөн хэмжээнээс 206.3 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2015 оны төлөвлөгөөнд 9 төсөл арга хэмжээг 593.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн батлагдаж 387.1 сая төгрөгийг бүрдүүлсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 206.3 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 09 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2016 оны төлөвлөгөөнд 2 төсөл арга хэмжээг 486.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна. 2016 оны эхний 8 сарын байдлаар 248.0 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний орлого хуульд заасан хувь хэмжээнээс багаар төлөвлөж, батлагдаж байгаа хэдий ч бүрэн төвлөрүүлж чадаагүй байна.

2015 онд сумдын Байгаль хамгаалах санд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан орлогын төрлөөр болон бусад орлогын эх үүсвэрийг задлан харууллаа. /мян.төг/

№	Сумын нэр	Орлого												Дүн
		Ой	ургамал	ББаялаг	ан	Ус	Нөхөн төлбөр	Үнэт цаас	Барьцаа	Тарвага нутаг-шуулах	Суулгац	Бусад	хог	
1	Алтанбулаг				4500.0								2445.4	6945.4
2	Аргалант	23.8	10206.0		4700.0	1915.2						75.0	1330.0	18250.0
3	Архуст								1000.0					1000.0
4	Батсүмбэр			300.0				316.1	300.0					916.1
5	Баян												240.0	240.0
6	Баяндэлгэр	55.2					1107.5	62.6			154.0			1379.3
7	Баян-Өнжүүл					1671.5								1671.5
8	Баянцогт											2980.0		2980.0
9	Баянчандмань	400.0				85.0	4596.3							5081.3
10	Борнуур						660.0							660.0
11	Бүрэн				7447.5					5000.0	0.0		646.5	13094.0
12	Жаргалант							149.7				37.8		187.5
13	Заамар								5452.0			200.0		5652.0
14	Лүн				4009.0									4009.0
15	Мөнгөнморьт	25.0						1469.1						1494.1
16	Өндөрширээт				1637.0									1637.0
17	Сүмбэр								775.0					775.0
18	Сэргэлэн				640.0									640.0
19	Угтаал	130.0	190.0										2038.6	2358.6
20	Цээл			2002.7			4650.4							6653.1
21	Эрдэнэ	27211.5	120.0					190.2						27521.7
22	Эрдэнэсант											6127.0	271.0	6398.0
	2015 оны нийт	27845.5	10516.0	2302.7	22933.5	13431.2	11014.1	2187.7	7527.0	5000.0	154.0	11479.8	6971.5	121363.0

2015 онд сумдын Байгаль хамгаалах сангийн нийт орлогын 109.5 сая төгрөгийн 71.5 хувь буюу 78.3 сая төгрөгийн орлого нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан орлого болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.1.4-д заасан нөхөн төлбөрийн орлого эзэлж, үлдэх 28.5 хувь буюу 31.1 сая төгрөгийн орлого нь үнэт цаасны орлого, барьцаа дансанд төвлөрүүлэх хөрөнгө, хог хаягдлын хураамж зэрэг бусад орлого эзэлж байна.

Бүлэг 3

Зарим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зураг төсөвгүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, зориулалтыг өөрчлөх, гэрээгээ дүгнээгүй байх зэрэг хууль, журам бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил байна.

В.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь хуулиар тодорхойлсон зорилго, зорилттой нийцэж байна уу?

Байгаль хамгаалах сангийн үлдэгдлийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр 2015 онд 9 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлснээс “Манзуширийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулж, менежментийг боловсруулах” төсөл, арга хэмжээнээс бусад төсөл, хөтөлбөрийг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол, аймгийн ИТХ-аар батлагдсан зориулалтын дагуу санхүүжүүлсэн байна.

2015 онд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт /сая.төг/

	Төсөл арга хэмжээний нэр байршил	Оны эхний үлдэгдэл	ИТХ-аар батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллыг цэвэр, бохир усны байгууламжтай болох		200.0	10.9	-189
2	Шинэчлэл цэцэрлэгт хүрээлэнд ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлэн дуусгах		61.4	61.4	0
3	Үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах төсөл хэрэгжүүлэх		161.5	161.5	0
4	Сумын БОХ-ын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум дундын ойн анги, идэвхтэн байгаль хамгаалагчдын сургалт зохион байгуулах		4.8	4.8	0
5	Усны тооллогыг явуулж, сав газруудын зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, ААН байгууллагын оролцоог нэмэгдүүлэн сургалт сурталчилгаа явуулах.		5.0	5.0	0
6	Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цэвэрлэх байгууламж барих /Сүмбэр сум/		80.0	80.0	0
7	Сумдын усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох төсөл арга хэмжээний нэр байршил тогтоох		26.0	26.0	0
8	Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх		24.5	0	-24.5
9	Манзуширын тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулах, менежментийг сайжруулах		30.2	30.2	0
	ДҮН		593.4	379.5	213.9

Манзуширийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулж, менежментийг боловсруулах 30.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Музейн барилгын өргөтгөлийн зураг төсвийн үнэнд 24.3 сая төгрөг зарцуулсан нь аймгийн

ИТХ-аар нэр зааж батлагдаагүй зардал гаргаж Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмыг зөрчсөн байна.

“Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-д компанитай 2015.10.29-ний өдрийн №UPI-05/2015 тоот гэрээгээр музейн гонх, тогооны суурийн ажлын зураг, төсөв, аялалын маршрутын судалгаа, самбар боловсруулах ажлыг 5.9 сая төгрөгөөр 2015.10.29-аас 2015.12.15-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан хэрэгжүүлсэн нь зориулалтын дагуу, 2015.12.01-ний өдөр Төв аймгийн Музейн барилгын өргөтгөл, тогооны суурийн ажлын зураг төсөл боловсруулах ажлын нэмэлт № UPI-05/2015 гэрээг Музейн дарга Б.Даваасүрэн, нөгөө талаас Хот төлөвлөлтийн хүрээлэнгийн ерөнхий менежер Ч.Батэрдэнэ нар харилцан тохирч 27.6 сая төгрөгөөр байгуулсан нь зориулалт бус байна.

Санхүүжилт 24.3 сая төгрөгийг 2015.12.24-ний өдөр Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Ү.Батчулуун, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Н.Хорлоо нар зөвшөөрөл олгосноор шилжүүлсэн байна. Энэхүү зураг төсвийг аймгийн ерөнхий архитектораар батлуулаагүй, гэрээг дүгнээгүй, хүлээлгэн өгсөн акт баримт байхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний бусад зардал нь зориулалтын дагуу байгаа хэдий ч аудитаар дараахь зөрчилүүд илэрлээ. Үүнд:

- Сумдын усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтооход 26 суманд тус бүрт 0.9-1.0 сая төгрөгөөр тооцож 26.0 сая төгрөгийг бүх сумдад шилжүүлж нэг сум 4-өөс доошгүй усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэн, хийгдэх ажлын зураг төсөв, ажлын тайлан мэдээг ирүүлэх талаар чиглэл өгч ажилласан гэх боловч сумдаас ирүүлсэн тайлан нотлох баримт байна.
- Гэр хорооллын дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулахад 10.6 сая төгрөг олгосон ба авлагаар тусгаагүй.
- Баянцогт сумын үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах 161.5 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахдаа ажил хийгдэж дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгож авлагаар тусгаагүй.
- Сүмбэр сумын Хөрсний бохирдлыг бууруулах цэвэрлэх байгууламж барих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх ажилд Ану сервис ХХК-д 2015.12.24-ний өдөр 80.0 сая төгрөгийг тендерийн баримт, ажил гүйцэтгэх гэрээ, ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан акт баримтгүй байхад шилжүүлсэн.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний чиг үүргийг гүйцэтгэж байсан аймгийн Байгаль хамгаалах сан нь 2014 оны жилийн эцсийн тайлангаар 72.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. 2015 онд тус санд тээврийн үйлчилгээний орлогоор 2.0 сая төгрөг, Аймгийн Засаг даргын А/558 тоот захирамжаар төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжилт 2.0 сая төгрөг, Хас банкнаас хяналтын зардалд гэрээний дагуу 7.7 сая төгрөг нийт 11.7 сая төгрөгийн орлого орж, 76.2 сая төгрөгийг “Бүтээн байгуулалт төслийн нэгж”-ийн үйл ажиллагаанд зарцуулж оны эцэст 7.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3-д заасантай нийцэхгүй байна.

2015 онд сумдын Байгаль хамгаалах санд төвлөрсөн хөрөнгийг захиран зарцуулахдаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2-д заасан заалт, ЗГ-ын 2014 оны 43 тоот тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга

хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журмын 3.1-3.5 заасан заалтын дагуу аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө, аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа, нөхөн сэргээлт, цалин урамшуулал, шатахуун, огтоно устгах, булаг шандны эх хамгаалах, гүүрийн засвар, хог хаягдлын зардал зэрэгт нийт 215.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

2015 онд сумдын Байгаль хамгаалах сангийн нийт зарлагын 263.5 сая төгрөгийн 81.7 хувь буюу 215.3 сая төгрөгийн зарлага нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2-д заасан заалт, Засгийн газрын 2014 оны 43 тоот тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах журмын 3.1-3.5-д заасан заалтын дагуу зарцуулж, 18.3 хувь буюу 48.2 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсан байна.

Зарцуулалтыг задлавал актын төлбөрт 15.4 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 18.9 сая төгрөг, хөрөнгө бэлтгэхэд 4.0 сая төгрөг, санхүүгийн программ авахад 0.5 сая төгрөг, өдөрлөгийн үйл ажиллагаанд 4.4 сая төгрөг, бусад зардалд 4.2 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Энэхүү зөрчилд 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөж зөрчлийг давтан гаргахгүй байх талаар сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж хүргэгдсэн байна.

Аймгийн Тусгай сангуудын үйл ажиллагааг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөх, хуваарилах, хэрэгжүүлэх, тайлагнах талаар Аймгийн ИТХ-ын 2016 оны гурав дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны 5 тоот тогтоолын 7.2-д Аймаг, сумын Байгаль хамгаалах санг татан буулгаж, сангийн журмыг хүчингүй болгон, байгаль хамгаалахтай холбоотой зардлыг аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөрт зардалд тусган төлөвлөж хэрэгжүүлэх гэсэн заалтын дагуу Байгаль хамгаалах сангийн 2015 оны үлдэгдэл 86.3 сая төгрөгийг аймаг, сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд татан төвлөрүүлсэн байна.

В.2. Төсөл хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАА тухай хуулийн дагуу сонгон шалгаруулсан уу

Зарим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зураг төсөвгүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, зориулалтыг өөрчлөх, гэрээгээ дүгнээгүй байх зэргээр хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлагдсан төсвөөр хийж гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАА тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулах замаар хэрэгжүүлсэн байна.

Харин Зуунмод сумын Одонт хөтөл дагуух Шинэчлэл-Цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах ажилд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын санхүүжилтээр 61.3 сая төгрөгийн, аймгийн ОНХСангаас 7.6 сая төгрөг нийт 68.9 сая төгрөгийг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАА тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулаагүй, эрх бүхий байгууллагын баталсан зураг төсөвгүйгээр тухайн үе шатны ажил тус бүрт нь төсөв хийж аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, аймгийн БОАЖГазар аж ахуйн аргаар хийж гүйцэтгэсэн байна.



Үүнийг тодруулбал: Цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа барих ажилд 11.3 сая төгрөг, ажлын хөлсөнд 4.4 сая төгрөг, тээвэр шатахуунд 9.1 сая төгрөг, материалын зардалд 3.6 сая төгрөг, хөрөнгө бэлтгэхэд 3.8 сая төгрөг, зүлэгний үр авахад 7.9 сая төгрөг, мод суулгац авахад 3.7 сая төгрөг, явган хүний зам тавих ажилд 15.2 сая төгрөг, 2014 онд хийсэн хашааны ажлын өглөг 5.2 сая төгрөг, зураг төсвийн үнэнд 4.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Тус ажлыг хийж гүйцэтгэхдээ тендер сонгон шалгаруулалт явуулаагүй, эрх бүхий байгууллагын баталсан зураг төсөвгүйгээр гүйцэтгэсэн байна.

Мөн Сүмбэр сумын нийгмийн салбарын төсөвт албан байгууллагуудад цэвэр усны шугам тавих 80.0 сая төгрөгийн ажлыг хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулаагүй, аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ажлын гүйцэтгэлийг үндэслэн Ану сервис ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАА тухай хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэсэн заалт, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

В.3. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр нь гэрээний шаардлагыг хангасан уу?

Зарим байгууллага, албан тушаалтнууд гэрээнийхээ хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлагдсан төсвөөр хийж гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хууль,

тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг цаг тухай бүрд нь сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулан, гэрээнийхээ шаардлагыг ханган ажилласан боловч зарим байгууллага, албан тушаалтнууд гэрээнийхээ хэрэгжилийг хангаж ажиллаагүй зөрчил байна.

-Манзуширийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулж, менежментийг боловсруулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зориулалтыг нь өөрчлөн Музейн барилгын өргөтгөл, тогооны суурийн ажлын зураг төсөл боловсруулах ажил болгон 27.6 сая төгрөгийн нэмэлт гэрээг Музейн захирал өөрөө баталж, өөрөө гэрээ байгуулсан боловч аймгийн ерөнхий архитектораар батлуулаагүй, гэрээгээ дүгнэлгүйгээр санхүүжилтийг олгосон.

-Цэцэрлэгт хүрээлэнгийн явган хүний замын зарим ажлыг БОАЖГазар нь “Төв АЗЗА” ТӨХК-иар 2015.06.25-наас 2015.07.02-нд 5.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр №13 тоот гэрээ байгуулсан, гэрээгээ дүгнээгүй, ажил хүлээж авсан комиссын акт байхгүйгээр гэрээнд заасан санхүүжилтийн бүрэн шилжүүлсэн байна.

-Аймгийн төвийн Зуунмод сумын Одонт хөтлийн зам дагуу Шинэ цэцэрлэгт хүрээлэнг 2015 онд 68.9 сая төгрөгийн төсөвт өртөгтөөр хийж гүйцэтгэхдээ тус ажлын зураг төсөв хийлгэхээр 2015.04.17-нд “Сонор хүлэг” ХХК-тай №01/15 тоот гэрээ байгуулан аймгийн Засаг даргаар батлуулж, энэ өдрөөс 1 сарын хугацаанд 9.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлэхээр гэрээнд тусган тус ажлын 50 хувь болох 4.7 сая төгрөгийг 2015.05.12-нд шилжүүлсэн байна. Гэвч уг компаниар гэрээний дагуу зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгүүлээгүй, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавиагүй, гэрээгээ дүгнээгүй, зураг төсвийг бүрэн хийлгэж албан ёсоор баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж зөрчсөн байгаа тул холбогдох албан тушаалтнуудаар хариуцуулан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

В.4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн үү?

2015 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлагдсан төсвөөр хийж гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдээс 3 төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2015 оны төлөвлөгөөнд 9 төсөл арга хэмжээг 593.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 2015 онд 8 төсөл, арга хэмжээг 387.1 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2015 онд батлагдан төсвөөр хийж гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдээс 6 төсөл, хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрсэн байна.

Төлөвлөгдсөн 9 ажлаас 224.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажил хийгдээгүй байна. Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллыг цэвэр, бохир усны байгууламжтай болох ажлыг 200.0 сая төгрөгөөр төлөвлөөд зураг төсвийн үнэ 10.6 сая төгрөгийг зарцуулж 189.4 сая төгрөгийн ажил төлөвлөсөн нь ондоо хийгдээгүй, Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх ажлын 24.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг тус тус хийж гүйцэтгээгүй дараа онд шилжин хийгдэж байна.

Манзуширын тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулах, менежментийг сайжруулах нэрээр батлагдсан төсөл арга хэмжээг нэр зориулалтыг

өөрчлөн Музейн барилгын өргөтгөлийн зураг төсвийг хийлгэн зориулалт бусаар зарцуулсан нь зорилтот үр дүндээ хүрээгүй байна.

Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 2016 оны төлөвлөгөөнд 2 төсөл арга хэмжээг 486.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2016 оны эхний 8 сарын байдлаар Лүн, Зуунмод сумын Усан санг автоматжуулах, тоолууржуулах төсөл арга хэмжээний зардалд 300.0 сая төгрөг төлөвлөснөөс 241.3 сая төгрөг, Аргалант, Зуунмод сумын голын эхэнд хөв, цөөрөм байгуулах төсөл арга хэмжээнд 186.3 сая төгрөг төлөвлөж зураг төслийн урьдчилгаанд 6.7 сая төгрөг тус тус зарцуулж нийт 238.3 сая төгрөгийн ажил хийгдэх шатандаа явж байна.

Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн

Бүлэг 4

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж байна.

Г.1. Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн үү?

Дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 4.3-д “Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ”, 4.7-д “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь тухайн аймаг, сумын байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын хүрээнд байгаль орчны нөөц ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэж болно” гэж заасан.

Гэвч аудитад хамрагдаж буй хугацаанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хэрэгжилтэнд болон байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн ажил байхгүй байгаа нь дотоод хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдээгүйг харуулж байна.

Г.2. Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдэж байна уу?

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хэрэгжилтэнд дотоод хяналт шалгалт хийсэн ажил байхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хэрэгжилтэнд болон байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн ажил байхгүй байна.

Аймгийн Аудитын газраас Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон Байгаль хамгаалах сангийн 2015 оны санхүүгийн тайланд санхүүгийн аудит, 2014 он, 2015 оны эхний хагас жилийн зарцуулалтанд гүйцэтгэлийн аудитыг тус тус хийсэн байна. Төрийн аудит буюу хөндлөнгийн хяналтаас өөр дотоод хяналт шалгалт хийгдэхгүй байна.

Г.3. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг ил тод нээлттэйгээр олон нийтэд мэдээлж байна уу?

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 2015 онд хэрэгжүүлсэн 9 төсөл арга хэмжээний, 2016 онд хэрэгжүүлсэн 2 төсөл арга хэмжээний зарцуулалтын мэдээллийг цаг тухай бүрд нь ил тод нээлттэйгээр мэдээлсэн байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны албанаас Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын худалдан авалтын төлөвлөгөө, тендерийн ерөнхий мэдээлэл зэргийг Шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.1.8-д Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор мэдээлнэ гэснийг хэрэгжүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга, хэмжээний зардлыг бүрдүүлж зарцуулахдаа Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолыг мөрдөж ажилласан байна.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулахаар төлөвлөсөн боловч “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18.1-д заасан хувь хэмжээнээс дутуу төлөвлөж, батлуулж ирсэн байна.
3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний зарим төсөл, арга хэмжээг батлагдсан зураг, төсөвгүй хийж гүйцэтгүүлэх, гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулаагүй, төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчлөх зэрэг зөрчил байна.
4. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг цаг тухай бүрд нь мэдээлж ажилласан байна.
5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга, хэмжээний зардлыг бүрдүүлж зарцуулахад тавих дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ, ГХБХБГазрын дарга М.Хүрэлбаатар, БОАЖГ-ын дарга Б.Болдбаяр нарт зөвлөх нь:

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу бүрэн төлөвлөж, төвлөрүүлэх
2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу, зураг төсвийг хийлгэн, гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах зэргээр тайланд дурьдагдсан зөрчлийг арилган хойшид давтан гаргахгүй байх
3. Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 4.3-т “Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ”, 4.7-д “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь тухайн аймаг, сумын байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын хүрээнд байгаль орчны нөөц ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэж болно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Холбогдох байгууллагын санал



ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

41100 Зууламд, Төв аймаг
Утас: 70273290, Факс: 70272457
E-mail: bosgg_tov@yahoo.com Цахим хуудас: baigali.to.gov.mn

2016.10.10 № 02/166
талай _____ ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол усан Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн /Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны үр дүн/, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Зарим тайлбарыг өгч, тайлангын үр дүнд гарсан холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА



Б.БОЛДБАЯР

My doc: A5 toot / 2016 /



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/21

Зуунмод

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 тоот тушаалын 11 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын нийтлэг эрх, үүргийн дүрэм" –ийн 2.2.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95-р тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтуудыг үндэслэн **ТУШААХ нь:**

1. Үндэсний аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгсөн төлбөрийн актыг 10330.4 мянган төгрөгөөр, албан шаардлагыг 80000.0 сая төгрөгөөр, 21 албан тушаалтанд арга хэмжээ тооцох албан шаардлагыг баталсугай.

3. Нийцлийн аудитаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмж, албан шаардлагын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Ц.Саранчимэг, аудитор Д.Пүрэвсүрэн нарт даалгасугай.

4. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллаж, илэрсэн алдаа зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжилтийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Төв аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт/- нарт зөвлөсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЖАРГАЛСАЙХАН

Дарга, тэргүүлэх аудиторов 2016 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн А/21 тоот тушаалын хавсралт

№	Төлбөрийн акт албан шаардлагыг хариуцсан барагдуулах		Зөрчлийн утга	Төлбөрийн актын дүн	Албан шаардлага	
	Байгууллага	Албан тушаалтан			Асги хэмжээ тооцох ажилтны тоо	Дүн
1	Батсүмбэр суман дахь Майндсет МСҮТ	Майндсет МСҮТ-ийн захирал Б.Галбадрах	Шинээр үйл ажиллагаа эхлэсэн бөгөөд сургалтын үйл ажиллагаа эхлээгүй байхад тэтгэлэг олгосон	2072.0		
2	Баянчандмань суман дахь МСҮТ	Захирал, сургалтын албаны менежер, нягтлан бодогч, анги удирдсан багш	24-өөс дээш насны суралцагчдад тэтгэлэг олгосон	1745.58		
3	Эрдэнэ суман дахь МСҮТ	Захирал, сургалтын албаны менежер, нягтлан бодогч, анги удирдсан багш	24-өөс дээш насны суралцагчдад тэтгэлэг олгосон	744.2		
4	Заамар суман дахь МСҮТ	Захирал, сургалтын албаны менежер, нягтлан бодогч, анги удирдсан багш	24-өөс дээш насны суралцагчдад тэтгэлэг олгосон	155.3		
5	Зуунмод суман дахь МСҮТ	Захирал, сургалтын албаны менежер, нягтлан бодогч, анги удирдсан багш	24-өөс дээш насны суралцагчдад тэтгэлэг олгосон	863.3		
6	Эрдэнэ суман дахь МСҮТ	Захирал, сургалтын албаны менежер, нягтлан бодогч, анги удирдсан багш	Суралцагчийн ирцийг бүртгэлийг үнэн зөв бодитой гаргаагүй багш нарт арга хэмжээ тооцох		6	
7	Төв аймаг Зуунмод суман дахь МСҮТ	Захирал, сургалтын албаны менежер, нягтлан бодогч, анги удирдсан багш	Суралцагчийн ирцийг бүртгэлийг үнэн зөв бодитой гаргаагүй багш нарт арга хэмжээ тооцох		15	
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан			Нийт дүн	5580.4	21	
8	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар	ГХБХБГ-ын дарга М.Хүрэлбаатар, мэргэжилтэн Д.Алтансүх, БОАЖГ-ын дарга Б.Болдбаяр, нягтлан бодогч Б.Дэлгэрцэцэг	Цэцэрлэгт хүрээлэнгийн Зураг төсвийг бүрэн хийж гүйцэтгүүлээгүй, албан ёсоор хүлээж авч, гэрээгээ дүгнээгүй, урьдчилгааг авлагаар тусгалгүй төсвийн зарлага болгосныг холбогдох албан тушаалтнуудаар төлүүлэх	4750.0		
9	Сүмбэр сумын Засаг дарга	Сүмбэр сумын Засаг дарга Р.Билэгсайхан, санхүү албаны дарга А.Ариунбаяр	АНУ Сервис ХХК-иар батлагдсан зураг төсөвгүй, сонгон шалгаруулалт хийлгүй шууд гэрээ байгуулан хийсэн ажлыг улсын комисс хүлээж аваагүй, ЗДТГ-ын ажлын комисст хүлээлгэн өгсөн боловч байгууллагын данс бүртгэлд тайлагнаагүй зөрчлийг арилгуулах			80000.0
Байгаль хамгаалах сан			Нийт дүн	4750.0	0.0	80000.0
Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн			Нийт дүн	10330.4	21	80000.0